



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/535

Булган сум

### Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Г.Мөнхбат (ГЮ90020417)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 16 дугаар  
гудамж 1646 тоотод байршилтай 6308000946 нэгж талбар бүхий амины орон сууц  
зориулалтаар эзэмшиж буй 784 м2 газрын газар эзэмших эрхийг Т.Бэхтөр (PP86040896)-  
д, Б.Баттулга (ГЮ76031319)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 16 дугаар гудамж 1664  
тоотод байршилтай 6308005383 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар  
эзэмшиж буй 597 м2 газрын газар эзэмших эрхийг Д.Бат-Эрдэнэ (ГЮ65121570)-д тус тус  
шилжүүлсүгэй.

2. Т.Бэхтөр, Д.Бат-Эрдэнэ нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж,  
гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга,  
хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/435  
дугаар захирамжийг, 2019 оны А/286 дугаар захирамжийн Б.Баттулгатай холбогдох  
хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ